



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/7/СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.dornogovi.audit.mn](http://www.dornogovi.audit.mn)

Дорноговь аймаг  
2020 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734      Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг

Утас: 70523020      Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn

Аудитор:                      У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: Oyuntulkhur.u@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад МӨРДСӨН БОДЛОГО, ЖУРАМ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ .....	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	5
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	6
2.8.1 Мөнгөн хөрөнгө .....	6
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт .....	
2.8.3 Авлага.....	6
2.8.4 Урьдчилгаа .....	
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт .....	
2.8.6 Бараа материал .....	7
2.8.7 Үндсэн хөрөнгө .....	8
2.8.8 Өр төлбөр .....	8
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	9
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.11. Шилэн дансны мэдээлэл .....	11
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	13
3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	15
3.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18
3.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	21
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	22
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	25
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	26

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

## 1. Аудитын гэрчилгээ



### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.03.23 № 1-6/346  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АЙРАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Л.МӨНХЖАРГАЛ ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Айраг сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Айраг сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Айраг сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01002009

III/23 1-6/345

### Үүрэг, хариуцлага

Айраг сумын Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА  
59  
1:30

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Айраг сумын Засаг дарга Л.Мөнхжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 06-аас 2020 оны 03 дугаар сарын 11-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 11-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Оюунтүлхүүр хариуцаж хэрэгжүүлэв.

Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 5/209 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

#### **2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр цэвэр хөрөнгийг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 7,819.3 сая төгрөгийн 1 хувь буюу 78.2 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

#### **2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 сан, ОНЕО-ийн нийт, 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2

байгууллага аудитын санал дүгнэлт, бусад 6 байгууллага, сан түүвэр аудитад хамрагдсан байна.

Аудитын санал дүгнэлтээр цэцэрлэг “Зөрчилгүй”, Ерөнхий боловсролын сургууль “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байна

Айраг сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 154.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 71.6 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 31.0 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 31.9 сая төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 19.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмжийг хүргүүлээ.

### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- ОНХсангийн 37.7 сая төгрөгөөр авлагыг илүү, 16.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дутуу, 37.7 сая төгрөгөөр өр төлбөрийг илүү нэгтгэснийг залруулсан

### Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 71.6 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- ОНХСангийн тайланд 53.9 сая төгрөгийн залруулга хийсэн.
- Ерөнхий боловсролын сургууль:
  - 9.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэснийг үндсэн хөрөнгийн дансанд залруулан бүртгэсэн
  - Төсвийн гүйцэтгэлийг буруу тайлагнасан 7.7 сая төгрөгийг залруулсан
  - Хангамжийн материалын дансанд бүртгэлтэй 0.3 сая төгрөгийн малыг мал дансанд залруулан бүртгэсэн

## **2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт**

### **2.8.1 Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 300.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 162.9 сая төгрөг болж 137.9 сая төгрөгөөр буурсан байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	300.8	162.9	-137.9	100.0
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
<b>Дүн</b>	<b>300.8</b>	<b>162.9</b>	<b>-137.9</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр тайлагнасан 162.9 сая төгрөгийг авч үзвэл:

Ерөнхий боловсролын сургуулийн Ахмадын сан 2.1 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 18.9 сая төгрөг, Сум хөгжүүлэх сангийн 56.4 сая төгрөг, Нөхөн сэргээлтийн сангийн 28.9 сая төгрөг, Нэмэлт дансны үлдэгдэл 56.6 сая төгрөг байна.

### **2.8.2 Авлага**

Авлага дансны эхний үлдэгдэл 76.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 204.0 сая төгрөг болж, 127.1 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт № Авлагын үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0	0	0
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага	0	0	0
Байгууллагаас авах авлага	20.1		
Зээлийн авлага	56.8	204.0	147.2
<b>Дүн</b>	<b>76.9</b>	<b>204.0</b>	<b>147.2</b>

Эх сурвалж: Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд:

- Сум хөгжүүлэх сангаас 2013-2015 онд олгосон 30.6 сая төгрөг, 2019 онд олгосон 173.4 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага байна. Зээлийн хугацаа хэтэрсэн 30.6 сая төгрөгийн авлагыг шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлсэн байна.

**2.8.5 БАРАА МАТЕРИАЛ**

Бараа материалын эхний үлдэгдэл 376.25 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 420.78 сая төгрөг болж, 44.53 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт №1. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт/+/ бууралт/-
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>376.25</b>	<b>420.78</b>	44.53
<b>Түүхий эд материал</b>	<b>40.61</b>	<b>59.15</b>	18.54
Тусгай зориулалттай материал	37.48	46.52	9.04
Эм боох материал	3.13	12.63	9.5
Дуусаагүй үйлдвэрлэл	0	0	0
Бэлэн бүтээгдэхүүн	0	0	0
<b>Хангамжийн материал</b>	<b>328.77</b>	<b>354.08</b>	25.31
Бичиг хэргийн материал	4.33	5.94	1.61
Аж ахуйн материал	10.92	10.48	-0.44
Сэлбэг хэрэгсэл	2.78	2.78	0
Түлш, шатах тослох материал	2.82	1.02	-1.8
Барилгын засварын материал	1.79	2.89	1.1
Хүнсний материал	15.92	11.62	-4.3
Бусад хангамжийн материал	290.21	319.34	29.13
Биологийн хөрөнгө	0	0	0
<b>Мал амьтад</b>	<b>6.87</b>	<b>7.56</b>	0.69

Эх сурвалж: Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**Аудитын илрүүлэлт:**

- **Ерөнхий боловсролын сургууль**

- Хүүхдийн хоолны зардал 14.7 төгрөгийн хүнсний материалд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй.
- Малыг зах зээлийн үнээс хэт доогуур үнээр үнэлсэн

## 2.8.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6700.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6877.4 сая төгрөг болж, 176.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>6700.6</b>	<b>6877.4</b>	<b>176.8</b>
Барилга, байгууламж, орон сууц	5655.2	5653.8	-1.4
Авто-тээврийн хэрэгсэл	67.6	167.6	100.0
Хуримтлагдсан элэгдэл	0.0	0.0	0.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	198.0	225.9	27.9
Хуримтлагдсан элэгдэл	0.0	0.0	0.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	135.1	148.3	13.2
Бусад үндсэн хөрөнгө	585.8	594.9	9.1
Дуусаагүй барилга, байгууламж	0.0	16.2	16.2
Ном	58.9	70.8	11.9
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>172.0</b>	<b>171.9</b>	<b>-0.1</b>
Програм хангамж	0.3	0.2	-0.1
Бусад биет бус хөрөнгө	171.7	171.7	0.0

*Эх сурвалж: Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд хандиваар 52.1 сая төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 296.0 сая төгрөгийн, шилжүүлэн авсан 107.3 сая төгрөгийн, бусад 139,5 сая төгрөгийн нийт 595.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

*Аудитын илрүүлэлт:*

- ЗДТГазар:
  - 3 газраас хандиваар нөүтбоок 2ш, компьютер 1ш, ковш машин 1ш авсан
- Эрүүл мэндийн төв:
  - Акталсан үндсэн хөрөнгийг устгал хийлгүйгээр данс, бүртгэлээс хассан

## 2.8.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 20.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1.5 сая төгрөг болж, 19.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>Өглөг</b>	<b>20.9</b>	<b>1.5</b>	19.4	100.0
Байгууллагад төлөх өглөг	20.9	1.5	19.4	100.0

*Эх сурвалж: Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Өр төлбөр дансанд Ерөнхий боловсролын сургуулийн 2019 онд 1.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл байна. 2019 онд ажилчдын ЭМ-ийн үзлэгийн төлбөр шилжүүлсэн боловч нэр данс зөрүүтэйгээр буцаж орсноос өглөг үүссэн.

### 2.8.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7605.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7835.5 сая төгрөг болж, 309.0 сая төгрөгөөр өссөн байна

Хүснэгт №31. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,372.0	3,372.0	-	43.0
Хуримтлагдсан үр дүн	2,838.9	3,108.4	269.5	39.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,394.6	1355.1	39.5	17.3
<b>Дүн</b>	<b>7605.5</b>	<b>7835.5</b>	<b>309.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Айраг сумын ИТХ-ын 2019 оны орон нутгийн төсөв батлах тухай 04/01 дугаар тогтоолд зааснаар тайлант онд 50.9 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 90.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 178.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	4.3	9.7	5.4	225.5
Хадгаламжийн хүүгийн орлого	13.9	19.1	5.2	137.4
Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	9.5	33.4	239	351.5
Хөрөнгө борлуулсны орлого	2.0	0.3	-1.7	15.0
Бууны албан татвар	1.7	2.2	0.5	129.4

Улсын тэмдэгтийн хураамж	1.5	3.3	1.8	220.0
Хог хаягдлын хураамж	15.7	16.3	0.6	103.8
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.8	1.9	1.1	237.5
Татварын алданги	0	2.9	2.9	
Хүү торгуулийн орлого	1.5	1.7	0.2	113.3
<b>Нийт дүн</b>	<b>50.9</b>	<b>90.9</b>	<b>41.6</b>	<b>178.5</b>

Орон нутгийн орлого 41.6 сая төгрөгөөр давсан нь 2019 онд Татварын ерөнхий газар татвар хураалтын шинэчилсэн программыг нэвтрүүлснээр, оны эхнээс сумын орлогын дансанд андуурагдаж ирсэн орлогыг жилийн дундуур аймгийн татварын албанаас ирүүлсэн албан тоотой нийт 257.7 сая төгрөгийн орлогыг залруулж, залруулгын тооцоо нийлээгүй 36.2 сая төгрөг үлдсэн байна.

Залруулаагүй 36.2 сая төгрөгийн орлогыг нэр төрлөөр нь задлахад:

- Үйл ажиллагааны орлого – 5.4 сая
- Хадгаламжийн хүүгийн орлого – 5.2 сая
- Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар – 19.6 сая
- Улсын тэмдэгтийн хураамж – 1.8 сая
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр – 1.1 сая
- Татварын алданги -3.0 сая
- Хүү торгуулийн орлого – 0.2 сая төгрөг тус тус байна.

Орон нутгийн давсан орлого 5.4 сая төгрөг Үүнд:

- Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар – 4.3 сая / 2018 оны ноосны урамшуулал орсон /
  - Бууны албан татвар – 0.5 сая төгрөг / өмнөх оны дутуу татвар /
  - Хог хаягдлын хураамж - 0.6 сая төгрөг / 2018 оны дутуу төлөлттэй 29 өрх, шинээр үүссэн 1 аж ахуйн нэгжийн төлсөн татварын орлогоор давсан /
- Нийт давсан 41.6 сая төгрөгийг аймгийн орлогын дансанд төвлөрүүлсэн.

- Хөрөнгө борлуулсны орлого -1.7 сая төгрөгөөр тасарсан. / Тухайн онд үл хөдлөх хөрөнгийн борлуулалт өмнөх оныхоос бага байсан нь төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн. /

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 29 хөтөлбөрт зориулан 2,199.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,199.6 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт 2,644.8 сая төгрөгийн зардлын 1,554.3 сая төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 782.9 сая төгрөгийг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 38.5 сая төгрөгийг, үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос 269.1 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,519.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 782.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 19.0 сая төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос 5.9 сая төгрөг нийт 2327.3 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдсэн байна. ОНХСангаас 34.8 сая төгрөг, ЭМДСангаас 19.5 сая төгрөг нийт 54.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу орсон.

Санхүүжилтийн хуваарилалтыг авч үзвэл.:

- Орон нутгийн байгууллагын санхүүжилт-433.7 сая төгрөг
- Тусгай шилжүүлгийн санхүүжилт- 1378.2 сая төгрөг

- Тогтмол зардлын санхүүжилт-349.2 сая төгрөг
- ОНХСангийн санхүүжилт- 141.3 сая төгрөг байна.
- ЭМДСангаас-19.0 сая төгрөг

Нийт зардлын гүйцэтгэл 2304.3 сая төгрөг болж 23.0 сая төгрөгийг эргүүлэн төвлөрүүлсэн.

Нийт зардлын гүйцэтгэл үзвэл:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил- 1,333.5 сая төгрөг
- АО-оос төлөх НДШ- 167.9 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал-354.7
- Хангамж бараа материалын зардал-51.9 сая төгрөг
- Нормативт зардал-94.6 сая төгрөг
- Эд хогшил, урсгал засварын зардал- 61.9 сая төгрөг
- Томилолт, зочны зардал-7.7 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж-35.1 сая төгрөг
- Бараа ажил үйлчилгээний бусад зардал-259.6 сая төгрөг
- Бусад урсгал шилжүүлэг-32.5 сая төгрөг
- Хөрөнгийн зардал-141.3 сая төгрөг

Нийт зардлын гүйцэтгэл 2304.3 сая төгрөг болж 23.0 сая төгрөгийг эргүүлэн төвлөрүүлсэн.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагчаас 6.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 40.6 сая төгрөг, хандив 31.0 сая төгрөг нийт 77.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Нийт 21.1 сая төгрөгийн зардал гарснаас

- Хангамж бараа материалын зардал-1.4 сая төгрөг
- Эд хогшил, урсгал засварын зардал-0.3 сая төгрөг
- Дотоод албан томилолт- 0.1
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж-18.3 сая төгрөг
- Бараа ажил үйлчилгээний бусад зардал-0.4 сая төгрөг
- Нэг удаагийн тэтгэмж-0.6 сая төгрөг

Үлдэгдэл 56.6 сая төгрөгийг ОНХО-т төвлөрүүлсэн.

## **2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

ЕБСургуулийн захирал Шүүхийн шийдвэрээр тогтоосон 13.3 сая төгрөгийн цалинг байгууллагын санхүүжилтээс олгосныг Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаар шийдвэрлэхээр шийдвэр гаргасан байна.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 151 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, огт байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй.

## **2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн байгууллага, сангуудын залруулагдаагүй зөрчлийн дүнг нэгтгэн үзэхэд 82.5 сая төгрөг байх бөгөөд үүнээс төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаар авч үзэхээр шийдвэрлэсэн 13.3 сая төгрөгийн зөрчлийг хассанаар нийт залруулаагүй алдаа зөрчлийг 69.2 сая төгрөгөөр тооцож бидний тогтоосон материаллаг байдлын түвшинээс бага байх тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

#### 3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>754,018.31</b>	<b>787,729.08</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>300,846.86</b>	<b>162,911.57</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>300,846.86</b>	<b>162,911.57</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>300,846.86</b>	<b>162,911.57</b>
31211	Төрийн сангийн харилцах	300,846.86	162,911.57
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>76,923.19</b>	<b>204,032.92</b>
<b>33600</b>	<b>Зээлийн авлага</b>	<b>56,792.92</b>	<b>204,032.92</b>
<b>33610</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>56,792.92</b>	<b>204,032.92</b>
33612	Хувь хүмүүст олгосон зээл	56,792.92	204,032.92
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>376,248.26</b>	<b>420,784.59</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>40,607.37</b>	<b>59,145.83</b>
35110	Тусгай зориулалттай материал	37,478.96	46,518.83
35130	Эм боох материал	3,128.41	12,626.99
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>328,768.09</b>	<b>354,079.37</b>
35410	Бичиг хэргийн материал	4,329.26	5,940.50
35420	Аж ахуйн материал	10,923.02	10,480.80
35430	Сэлбэг хэрэгсэл	2,783.81	2,782.22
35440	Түлш, шатах тослох материал	2,816.38	1,017.55
35450	Барилгын засварын материал	1,792.93	2,891.62
35460	Хүнсний материал	15,916.28	11,623.72
35470	Бусад хангамжийн материал	290,206.42	319,342.96
35600	Мал амьтад	6,872.80	7,559.40
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,872,598.55</b>	<b>7,049,285.71</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>6,872,598.55</b>	<b>7,049,285.71</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>6,700,567.38</b>	<b>6,877,403.30</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,667,004.12	5,785,023.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,846.55	-131,261.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	185,451.80	311,766.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	-117,896.06	-144,176.30
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	624,297.59	695,319.94
39206	Хуримтлагдсан элэгдэл	-426,282.88	-469,447.96
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	254,340.82	286,420.42
39208	Хуримтлагдсан элэгдэл	-119,256.05	-138,138.81

39214	Бусад үндсэн хөрөнгө	891,681.56	994,080.02
39215	Хуримтлагдсан элэгдэл	-305,851.11	-399,193.84
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0	16,169.27
39217	Ном	58,924.14	70,841.83
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>172,031.17</b>	<b>171,882.42</b>
39301	Програм хангамж	2,825.00	2,825.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,485.83	-2,634.58
39303	Бусад биет бус хөрөнгө	171,692.00	171,692.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>7,626,616.86</b>	<b>7,837,014.80</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>20,971.68</b>	<b>1,500.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>20,971.68</b>	<b>1,500.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>20,971.68</b>	<b>1,500.00</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>20,971.68</b>	<b>1,500.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	20,971.68	1,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,605,645.18</b>	<b>7,835,514.80</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>7,605,645.18</b>	<b>7,835,514.80</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,372,037.36	3,372,037.36
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,838,971.63</b>	<b>3,108,380.43</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	3,042,110.42	2,877,823.58
51220	Тайлант үеийн үр дүн	-203,138.79	230,556.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,394,636.18	1,355,097.01
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>7,626,616.86</b>	<b>7,837,014.80</b>

### 3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

